

НЭР ТОМЬЁОНЫ ОРЧУУЛГЫН АСУУДАЛД

(Усны барилга байгууламжийн нэр томьёоны жишээгээр)

Ц.Одончимэг¹⁸, С.Дугармаа¹⁹

Товч утга: *Усны холбогдолтой үг хэллэгт гадаад үг хэрэглэх нь элбэг болж байгаа нь нэр томьёоны асуудал жигдрээгүй, нэг мөр цэгцрээгүй байгаатай холбоотой. Нэр томьёо бүрийг орчуулж, заавал монгол үгээр оноох нь зөв үү, эсвэл, гадаад хэлний үг хэллэгийг авч хэрэглэх нь зөв үү гэсэн асуудлыг хөндөн бичлээ. Энэ өгүүлэлд усны барилга байгууламжийн төсөл хөтөлбөр, эрдэм шинжилгээ, хайгуул судалгааны ажлын тайлангаас мөн усны аж ахуйн нэр томьёоны тайлбар толиос жишээ баримтыг түүвэрлэн зэрэгцүүлэн жишиж харуулахыг оролдлоо.*

Бид судалгаандаа усны салбарын мэргэжилтэнүүд өргөн хэрэглэдэг Монгол Улсын зөвлөх инженер, Байгаль орчны гавьяат ажилтан Н.Чагнаа гуайн 2006 онд гаргасан 1334 үг хэллэг бүхий “Усны аж ахуйн нэр томьёоны тайлбар толь” болон “Шүрэнгийн УЦС” болон “Орхон гол дээр урсацын тохируулга бүхий ус хуримтлуулах сан байгуулах” төслийн хүрээнд Сэлэнгэ мөрөн, Байгал нуурын сав газрын Бүс нутгийн байгаль орчны үнэлгээний ажлын даалгаврын төслийн баримт бичгийн орчуулгын жишээг ашигласан.

Бид усны барилга байгууламжийн нэр томьёог бүтцийн хувьд монгол хэлний дүрмийг баримтлах нь зүйтэй болохыг, мөн орчуулгын болон хэрэглээний талаас оновчтой сонгохыг жишээ баримтаар тодотгон өөрсдийн санаагаа дэвшүүлээ.

Түлхүүр үг: *нэр томьёо, үг, орчуулга, ус, усны барилга байгууламж*

Оршил

Усны төсөл, хайгуул судалгаа, шинжилгээний ажил, зураг хийх, түүнчлэн бид өдөр тутам түгээмэл хэрэглэгддэг усны холбогдолтой үг хэллэгийг зөв хэрэглэх шаардлагатай.

Манай улсын усны аж ахуй хөгжихийн хирээр энэ салбарт гадаад харилцаа өргөжин тэлж, гадаадын хамтын ажиллагааны томоохон төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнтэй холбогдуулан устай холбогдолтой нэр томьёог жигдлэх, гадаад хэлнээс зөв орчуулан оноох асуудал нь тус салбарынхны хувьд чухал болжээ. Гадаад хэлнээс

¹⁸ ШУТИС-ийн ГХС-ийн Англи хэлний тэнхим

¹⁹ ШУТИС-ийн ГХС-ийн Англи хэлний тэнхим, (Ph.D)

хуулбарлан тогтоосон нэр томьёо нь шинжлэх ухааны аль ч салбарт дийлэнх хувийг эзэлдэг. Нэр томьёог орчуулан хэрэглэхдээ монгол хэлний үг бүтэх ёсыг дагаж мөрдөх нь албан бичиг боловсруулах шаардлагад нийцэх ба цаашид монгол хэлний нэр томьёог оноон жигдлэхэд чухал гэж үзэж байна.

Нэр томьёо үүсмэл үг болох нь

Нийгэм өөрчлөгдөн хөгжихийн хирээр гадаад хэлнээс олон шинэ үг хэллэг, нэр томьёо нэвтрэх боллоо. Өмнө байсан Улсын нэр томьёоны комисс /УНТК/-ын үйл ажиллагаа зогссоноор нэр томьёог боловсруулах, хянах, хэвшүүлэх байгууллага үгүй болж салбар салбарын нэр томьёог тогтооход тухайн салбарынхан болон хэлний мэргэжлийн хүмүүс холбоогүй болж, улмаар дур зоргоороо, зөв буруу нэр томьёо тогтоох, нэг ухагдахууныг өөр өөрөөр оноох зэргээр эх хэлний хэм хэмжээг зөрчин, зарим нь нийгэд хэвших хандлагатай болж байна.

Аливаа хэлний бүтээвэр, үг, холбоо үг зэрэг бэлэн байгаа нэгж, хэлбэрт тулгуурлан шинэ үг бүтэх арга, хэрэглүүр зүй тогтлыг судлах хэл шинжлэлийн ухааныг үг бүтэх ёс гэдэг. Үг бүтэх ёсны судлах зүйл нь үүсмэл үг юм. Жишээлбэл: боох гэсэн үгнээс үүдэлтэй усыг боох гэсэн утгаар боо-мт, мөн далан гэдэг үг тухайн дал хэлбэр, түүнээс үүдэн “далан” буюу усыг хаших, хаах зориулалт бүхий нэр томьёо үүссэн байх боломжтой юм. Харин техникийн бичиг баримтад дараах байдлаар далан, боомт гэсэн нэр томьёог хайхрамжгүйгээр сольж хэрэглэх тохиолдол элбэг юм. Үүнийг төлөвлөж буй “Шүрэнгийн УЦС” болон “Орхон гол дээр урсацын тохируулга бүхий ус хуримтлуулах сан байгуулах” төслийн хүрээнд Сэлэнгэ мөрөн, Байгал нуурын сав газрын бүс нутгийн байгаль орчны үнэлгээний ажлын даалгаврын төслийн баримт бичгийн орчуулгын жишээгээр харуулахад:

..identified six possible dam site located in Khyalganat and Zuunburen.

.. зургаан боломжит далангийн хөндлүүрийн байршлыг тодорхойлсон.

Зөв хувилбар нь: .. зургаан боломжит боомтын хөндлүүрийн байршлыг тодорхойлсон.

Усны барилга байгууламжийн нэр томьёог жигдлэх, оноон тогтоох асуудалд цаашид дараах зарчмуудыг зайлшгүй харгалзах шаардлагатай юм. Нэр томьёо судлаач Ч.Догсүрэн өөрийн бүтээлдээ монгол хэлэнд нэр томьёог тогтооход баримтлах үндсэн хэд хэдэн зарчмууд байдгийг дурдаад үүндээ:

1. Монгол бичгийн болон ярианы хэлэнд байсан уламжлалт үгсийг тэр хэвээр нь буюу шууд утгаар нь хэрэглэх
2. Монгол хэлний үгсийн сан дахь түүхэн ба хуучирсан үгийг шинэ утгаар нь сэргээн хэрэглэх
3. Монгол бичгийн болон ярианы хэлний зарим үгийн утгыг шилжүүлэн хэрэглэх
4. Монгол хэлнийхээ үг бүтэх аргыг ашиглан шинэ нэр томьёо бий болгох
 - а/ дагаврын аргаар хэлбэржүүлэх
 - б/ дан үгийг нийлэмж үг, нийлмэл үг болгох
 - в/ үг хураах

5. Нутгийн олон аялгууны үгээс оновчтой заримыг нь авч хэрэглэх
6. Гадаад хэлний буюу олон улсын чанартай нэр томъёог хуулбарлан орчуулах
7. Гадаад хэлнээс зонхилон олон улсын чанартай нэр томъёог зээлдэн авах (1988: х.12) гэж өгүүлжээ.

Аливаа хэлний үүсмэл үг нь үүсмэл бус үгээс олон бөгөөд хэлэнд шинэ үг үүсэх хэдэн түгээмэл арга байдаг бөгөөд судлаачид монгол хэлний хувьд залгавраар шинэ үг үүсэх арга зохилдог гэж үздэг. (Томтогтох, Г. 2012)


Дагавар нь дангаараа бие даасан утгагүй, үгийн үндсэнд шинэ утга оруулах буюу үг хоорондын харилцааг илтгэх үүрэгтэй юм.

Усны барилга байгууламжийн нэр томъёонд “-гч” дагавар нь үйлийн эзэн, эсвэл, тухайн үйлийг гүйцэтгэх мэргэжлийн нэр, мөн үйл хөдлөлийг гүйцэтгэх багаж, тоног төхөөрөмжийн нэрийг үүсгэж байна. Жишээ нь: degasifier-хий зайлуулагч, water consumer-ус ашиглагч,

“-уур, -үүр” дагавар нь багаж хэрэгслийг нэрлэн мөн идэвхтэй хэрэглэгдсэн байна. Уг дагаврыг эгшиг зохицуулан залгах ба зөөлөрсөн гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгахдаа “ь”-г “и” болгон уг дагаврын бүтцэд орсон урт эгшгийн нэгийг хасаж, урт эгшгээр төгссөн үгэнд залгахдаа “г” гийгүүлэгч жийрэглэнэ. Жишээ нь: water outlet opening-ус гаргуур, Inclined drop -түргэн урсгуур, гатлуур, settling basin- тунгаагуур,

“-вч” дагавар нь мөн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэр үүсгэх үүрэгтэйгээр ихэвчлэн ордог байна. Жишээ нь: dam core- боомтын зүрхэвч, халхавч, тэслэвч,

Харин “-лт” дагавар үйл явц заасан үг үүсгэх ба мөн тус дагаврын тусламжтай нийлмэл үгээр бүтсэн нэр томъёо цөөнгүй байна. Жишээ нь: drainage-хатаалт, dift-түрэлт, draught- таталт



Дээрх графикаас харахад усны барилга барилга байгууламжид багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмж заасан –уур, үүр дагавар бүхий нэр томьёо элбэг болохыг харуулж байна.

Мөн түүнчлэн “үг нийлэх” аргаар бүтсэн нэр томьёо олонтаа байна. Тус арга нь энгийн үгтэй адил юмс үзэгдэл, ухагдахууныг нэрлэдэг боловч энгийн үгнээс илүү дэлгэрэнгүй байдаг учир тус салбарын нэр томьёо бүтэхэд багагүй хэрэглэгддэг. Гэвч тухайн нэр томьёог бүрэн илэрхийлж байгаа гээд тухайн ухагдахууныг тайлбар мэтээр оруулах нь зохисгүй юм. Энэ нь нэр томьёо товч, ойлгомжтой байх зарчмаас гажна. Иймд нийлмэл нэр томьёоны бүрэлдүүлэгч нь хоёроос дээшгүй байх зарчмыг ихэвчлэн баримтлах хэрэгтэй. Жишээ нь: гадаргууны ус, усны баланс, хагшаасны зарцуулга, аригт усалгаа

Найруулах аргаар бүтсэн нийлмэл нэр томьёо

Нэр үг дараагийнхаа нэр үгтэй тийн ялгалын нөхцлөөр холбогдон захирагдаж бүтсэн нэр үгийг найруулах аргаар бүтсэн нийлмэл нэр үг гэнэ. Нэр үгийг нөгөө нэр үгэнд харьяалахын тийн ялгалын нөхцлөөр захируулан холбож найрсан хавсраа нэр үг бүтдэг. Жишээ нь: усан тээвэр, шүүрийн шүүрүүл, хийн гаргуур


Хамжуулах аргаар бүтсэн нэр томьёо

Эхний үг нь арынхаа үгтэй үндсээрээ, эсвэл, нэрийн тийн ялгал, үйлийн тодотгон холбох нөхцлөөр хамжуулан холбон бүтсэн нийлмэл үг арвин байна. Жишээ нь: тэнцвэржүүлэх сан, ус авах барилга, хог барих сараалж, ус зайлуулах хоолой,

Үг хорших арга

Харилцан эрх тэгш зэрэгцэн хоршиж нийлсэн нийлмэл үгийг хоршоо үг гэдэг. Үг хорших арга нь усны барилга байгууламжийн нэр томьёонд ховор байна. Жишээ нь: булаг шанд,

Мөн усны барилга байгууламжийн нэр томьёонд олон улсын шинж чанартай гадаад үгс нэлээд байх ба хуучны сурах бичгүүдэд үндэсний хэв шинж агуулсан хуучирсан үг хэллэг агуулсан байдаг нь зарим тохиолдолд оновчгүй байгаа нь илэрхий байгаа юм. Жишээ нь: аадар тавилуур, садраа адаг,



Графикаас харвал монгол хэлэнд нийлмэл нэр томьёо үүсэхэд зэрэгцсэн холбоос бүхий найруулах, хамжуулах аргууд түгээмэл байдаг нь ажиглагдаж байна. Нийлмэл үгийн бүрэлдэхүүнд орсон үгс нь салангид байхдаа ямар нэг байдлаар илтгэж байсан утгаа алдах бөгөөд нөгөө үгтэйгээ хамт ухагдахууныг бүрэн илэрхийлж, нэг юм үзэгдлийн нэрлэлт болдог.

Нэр томьёог орчуулах нь

Монгол орны нийгэм эдийн засгийн байдал өөрчлөгдөж, дэлхийн олон улстай нээлттэй харилцах болсноор шинжлэх ухаан-техникийн дэвшлийг хурдацтай тусган авч, энэ хирээр шинэ нэр томьёо олноор бий болж тэдгээрийг орчуулах, оноох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Нэр томьёо оноон тогтоохдоо нэр томьёог орчуулах аргуудыг эзэмших нь чухал. Нэр томьёо орчуулахад дараах аргуудыг хэрэглэж байна. Үүнд:

Дүйлгэн орчуулах арга

Дүйлгэх гэдэг нь нэг хэлний нэрлэсэн ухагдахууныг нөгөө хэлэнд байгаа үг хэллэгтэй яг тааруулан буулгахыг хэлнэ. Эх хэлний үг хэллэгийг өөр хэлээр орчуулан хөрвүүлэхэд хэлэнд нь үүрэг болон хэлбэрээр дүйцсэн үг байхгүй тохиолдолд хэлбэрээр нь бус үүргийг нь харгалзан ойролцоо үгээр дүйлгэх аргыг хэрэглэдэг. (Туул Д, Туяа Г, Тунгалаг Ц., 2012)

Жишээ нь: degistion chamber- ялзруулах хорго, agricultural lands-эдэлбэр газар, sorbtion- шингээх үйл явц, spring flood – шар ус, surge tank - тэнцвэржүүлэх сан, surge tank - тэнцвэржүүлэх сан

Хуулбарлах буюу үгчлэн орчуулах арга

Эх хэлний үгийг загварчлан буулгахыг хэлнэ. Үгчлэн орчуулахад юуны өмнө үг үгээрээ буусан монгол үг тухайн юм үзэгдэл, ойлголтыг цаад хэлээр байгаа үгийн дайтай төлөөлж байгааг сайтар ажиглах хэрэгтэй. (Туул Д, Туяа Г, Тунгалаг Ц., 2012) Жишээ нь: *filtration*-шүүрүүлэх давхраа, *sludge water*-лагийн ус, *fish pass*-загасны гарц, *crest length*- хярын урт, *water supply*-усан хангамж гэх мэт

Галигчлан буулгах арга

Нэр томъёог орчуулахад галигчлан буулгах арга нэлээд өргөн хэрэглэгддэг бөгөөд энэ нь орчуулж буй хэлэнд дүйх, тохирох оновчтой үг байхгүйн үндсэн дээр цаад ухагдахууныг тодотгон, тэмдэглэж байгаа ухагдахууныг товч тодорхой хадгалах үүднээс хэрэглэх болсон гэж үздэг. Энэ арга нь цагаан толгойн үсгийн галигийг харгалзан өөр цагаан толгойн тухайн галигт тохирох үсгээр буулгах явдал юм. Галигчлан буулгах арга нь тухайн хэлний үгийн санг шинэ үгээр баяжуулах эерэг талтай ч жирийн уншигчдын санаанд бодит утгаараа буухгүй байх тохиолдол бий. (Туул Д, Туяа Г, Тунгалаг Ц., 2012) Жишээ нь: *colmatage*-кольматаци (бөглөрөл), *melioration*- мелиораци (сайжруулалт), *дериваци* (усан зангилааны доод хашицын гол суваг)

Тайлбарлан орчуулах арга

Дээрх аргуудаар орчуулах боломжгүй үед хэрэглэдэг. Энэ нь эх хэлний үгийн сангийн нэгжийн утгыг орчуулгын хэлэнд их, бага хэмжээгээр тайлбарлан хөрвүүлснийг хэлнэ. Тайлбарлан орчуулах арга нь үгчлэн орчуулахтай уялдан гарч ирдэг. Үгчлэн орчуулах аргын нэг хэлбэр болох зээлдэх буюу хуулбарлан орчуулах аргын үед “тэг” утгатай гадаад үгийг хөрвүүлэх хэлэнд буулгадаг. Энэ үед “тэг” утгатай гадаад үгийг хөрвүүлэх хэлэнд орчуулах арга нь “тайлбар зүүх” арга болно. Уг тайлбар нь тухайн үйлийн утга/үүрэг хэлбэрийн талыг бүрэн тусгасан эх хэлнийх нь утгыг тодорхой илэрхийлсэн тайлбар байх шаардлагатай юм. (Туул Д, Туяа Г, Тунгалаг Ц., 2012) Жишээ нь: *electric power output of hydroelectric depending on maximum permissible discharge* -УЦС-ийн чадлаар илэрхийлэгдсэн цахилгаан эрчим хүч, *elevation-water table area curve (of discharge reservoir or a lake)*- хиймэл нуурын (байгалийн нуурын) усан гадаргын өөрчлөлтийн муруй, *water electrical conductivity*-усан цахилгаан станцын дамжуулах чанар, *arch dam* - хүндийн хүчний нуман боомт

Дүгнэлт

Нэр томъёог тогтоох, жигдлэхэд хуучирсан нэр томъёоны хэрэглээ, шинэ үүссэн оновчгүй нэр томъёо, эсвэл, гадаад үгийг зээлдэн хэрэглэх, гадаад хэлнээс орчуулан хэрэглэхдээ монгол хэлний дүрмийг баримтлах зэрэг асуудлыг анхаарах шаардлагатай байна.

Монгол хэлний үгийн бүтэц нь хэлний тогтвортой нэгж бөгөөд үг бүтээх дагаврыг зөв хэрэглэх нь тухайн салбарын мэргэжилтнүүд бичиг баримт боловсруулах, мөн гадаад хэлнээс орчуулахдаа анхааран дагах зүйлийн нэг юм.

Техник, технологийн нэр томъёог боловсронгуй болгоход тухайн салбарын мэргэжилтнүүдийн оролцоо зайлшгүй шаардлагатай байна.

Монгол хэлэнд нэвтэрч буй гадаад үгийг оновчтой орчуулахын тулд орчуулгын аргуудыг судлан мэргэжлийн нэр томъёо, үг хэллэгийг зөв оноон хэрэглэх нь нэр томъёог жигдлэх асуудлыг шийдэх арга замын нэг болов уу гэж бид үзэж байна.

Шинжлэх ухааны салбар бүрийн нэр томъёоны сан хөмрөгийг бүрдүүлж орчин үеийн дэвшилтэт техник, технологи, мэдээлэл холбооны технологийн боломжийг ашиглан нэр томъёог нээлттэй хэрэглэх боломжийг мэргэжилтнүүд болон олон нийтэд олгох нь бидний нэн даруй шийдэх асуудал болжээ.

Ашигласан ном хэвлэл

1. Догсүрэн Ч. “Монгол нэр томъёог оноох, томилох, жигдлэх асуудалд” УБ.1988
2. Томтогтох, Г. “Хэл шинжлэлийн удиртгал” УБ., 2012
3. Туул Д, Туяа Г, Тунгалаг Ц. “Орчуулгын онол дадлагын үндэс” УБ., 2012
4. Чагнаа Н. “Усны аж ахуйны нэр томъёоны тайлбар толь” УБ., 2006
5. Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам, УБ., 2003

Resume

The paper discusses on terms related to hydraulic structures, water treatment and usage of ground water. Word formation of Mongolian is essential for use of translated terms in Mongolian. Translating terms into Mongolian is considered as essential issues for the project documents whereas many borrowed terms and words from foreign languages are used in Mongolian. In our case we have focused on some translated terms and words from English to Mongolian. When we translate terms from foreign languages to Mongolian we have to closely cooperate with professionals in different field of science and technology.